



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/10

Жаргалтхаан

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны төсвөөр хийгдэх “Хүүхдийн хоол хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Н.Отгонбаяр – Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Т.Сүрэнцэцэг – Нийгмийн бодлогын мэргэжилтэн


Гишүүд: М.Ундрал – Хөдөлмөр эрхлэлт, халамжийн

асуудал хариуцсан мэргэжилтэн

Н.Энхзул–Нягтлан бодогч

Г.Жавзанжамъян - Нярав

2.Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд чанартай зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан гэрээ байгуулах, бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг үнэлгээний хороо (Н.Отгонбаяр)-д даалгасугай.



ДАРГА

С.ГАНБАТ